

Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, судалгаа, тайлагналт хариуцсан Ахлах шинжээч, Лувсанзундуй Ариунтунгалаг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.2. Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиг хандлагыг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлно.							
1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Салбарын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийн тоо	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын арга хэмжээ тусгагдаж батлагдсан байна.	Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-т заасны дагуу "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					салбарын 47 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 85 төсөл, арга хэмжээний саналыг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.8.2-т заасан 6.8.2.а.зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх; 6.8.2.б.үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тооцож боловсруулсан байх гэсэн шаардалгын дагуу боловсруулж Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. Хавсралт: 1 файл			
2	Салбарын улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Төлөвлөгөөний төсөл -1 Хүргүүлсэн албан бичиг	Салбарын улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд салбарын арга хэмжээ тусгагдаж батлагдсан байна.	Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 18.1-т Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%	

				захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар баталсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын нийт 32 саналыг нэгтгэн боловсруулж Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хугацаанд ТНБД-ын 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 2/144 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. ЭЗХЯ-аас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой уялдуулан нэгтгэн боловсруулж Засгийн газарт		
--	--	--	--	---	--	--

					танилцуулахдаа салбарын саналыг эрэмбэлэн салбарын 9 төсөл, арга хэмжээг нэгтгэлд тусгаж 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар баталсан. Хавсралт: 5 файл		
3	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлах	Батлагдсан стратеги төлөвлөгөө -1	Соёлын сайдын 2021 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын яамны стратеги төлөвлөгөө (2021-2024)	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод тулгуурлан, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшнийг баримтлан Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны ерөнхий чиг үүргийн хүрээнд 8 стратегийн зорилт, 139 арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөө, хэрэгжүүлэх	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

					арга хэмжээг боловсруулж сайдын 2025 оны А/78 дугаар тушаалаар батлуулсан. Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйг баримтлан боловсруулсан. Төслийг боловсруулахдаа салбарын 9, нийтлэг мөрдөгддөг 97, олон улсын гэрээ, конвенц зэрэг нийт 120 хуулийн хүрээнд мандатын шинжилгээг хийж 10 ерөнхий, 16 үндсэн, 85 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон. Хавсралт: 3 файл		
4	“Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын 2020-2025 оны	Тайлан-1	-	Салбарын зорилтуудын тайланг нэгтгэн	Бодлогын баримт бичгийн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын 2020 –	4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

	хэрэгжилтийн тайлан боловсруулах дэд ажлын хэсэгт ажиллах			боловсруулж Ажлын хэсэгт хүргүүлсэн байна.	2025 оны хэрэгжилтийн тайлангийн төслийг ССАЖЗЯ-ны хэрэгжилтийн хүрээнд нэгтгэн боловсруулж ажлын дэд хэсгийн зөвлөхүүдэд хүргүүлсэн. Зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжийн дагуу батлагдсан шалгуур үзүүлэлтээр хязгаарлагдахгүй дараах томоохон үйл ажиллагаануудыг тоон үзүүлэлттэйгээр гаргасан.Үүнд: -Хууль эрх зүйн шинэчлэл -Соёлын бүтээлч үйлдвэрлэл - Соёлын сэргэлт аян -Бүх нийтийн соёлын боловсрол -Монгол Урлаг дэлхийн тайзнаа -Монгол өв ба дэлхий дахин - Соёл, урлагийн байгууллагын статистик үзүүлэлтүүд. Мөн Эдийн засгийн тэргүүлэх чиглэл зорилтын хэрэгжилийн тайланд Аялал жуулчлал, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тайлангийн төсөл, инфографик бэлтгэн зөвлөхийн багт хүргүүлсэн. Хавсралт: 4 файл		
5	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд	Мэдээлэл танилцуулга - 6	-	Салбарын мэдээлэл,	Засгийн газраас Монгол Улсын 21 аймгийг 6	4-р сар, 5-р сар, 6-р	100%

	бүсийн зөвлөлийн хуралдаанд хамтран ажиллах			танилцуулгыг бүс бүрээр нэгтгэн боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн байна.	бүсээр хөгжүүлэх шийдвэр гарч, эдийн засаг, хөгжлийн форум, уулзалтыг бүс бүрт зохион байгуулах ажлын хүрээнд хангай, хойд, говь, төв, зүүн бүсэд зохион байгуулагдах удирдах ажилтны зөвлөгөөнд сайд, төрийн нарийн бичгийн даргын танилцуулах илтгэлийг нэгтгэн боловсруулж бүсүүдийн ажлын хэсэгт хүргүүлсэн. .	сар		
1.4. ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9.3, 22.9.6, 22.9.11 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах								
6	ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9.3, 22.9.6-т заасны дагуу соёл, спортын салбарын хөнгөлөлт эдлэх шаардлага боловсруулж батлуулах, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх	Батлагдсан шаардлага -1 Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн эсэх	-	Шаардлагын төсөл боловсруулж сайдын тушаалаар батлуулж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.3, 22.9.6-т заасныг үндэслэн “Шаардлага батлах тухай” Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалын төслийг боловсруулж сайдын 2025 оны А/175 дугаар тушаалаар батлуулсан. “Шаардлага батлах тухай” тушаалын төслийг бэлтгэхдээ Захиргааны ерөнхий хуулийн 61.6 дахь хэсэг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 147 дугаар тушаалаар баталсан “Захиргааны	4-р сар, 5-р сар, 6-р сар		100%

					хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу нөлөөллийн шинжилгээ. Шаардлага нь нийт хоёр хавсралттай. Нэгдүгээр хавсралтад соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд нийт нийт 4 бүлэг, 9 заалт, 11 хэсэгтэй. Хоёрдугаар хавсралтад спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, монголын үндэсний олимпын хороо, монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон		
--	--	--	--	--	--	--	--

					санхүүгийн дэмжлэг хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд нийт 4 бүлэг, 9 заалт, 11 хэсэгтэй. Батлагдсан шаардлагыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 7255 дугаарт бүртгүүлсэн. Хавсралт: 2 файл		
3.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
7	Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Байгууллагын стратегийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулах	Тайлан - 1	2024 оны биелэлт	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу салбарын төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, ТББ, эрдэм шинжилгээний байгууллагуудаас санал авахаар албан бичгийн төсөл боловсруулсан.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	50%
3.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
8	ССАЖЗ-ын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ажиллах	Дэд хорооны төлөвлөгөөний хэрэгжилт	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, дэгийн төсөлтэй танилцаж санал өгөх, дэд хорооны 2 удаагийн хуралд нийт 9 гомдол мэдээллийг хянан шийдвэрлэхэд санал өгч	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%

				оролцож, дүгнэлт тэмдэглэлтэй танилцан гарын үсэг зурах, Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах” цахим сургалтад тус тус хамрагдсан. Ёс зүйн дэд хороонд Говьсүмбэр аймгаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.7-т заасан журмын хүрээнд хариуцан хянан шалгалт хийж ажилласан. Жич: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагууд гомдол мэдээлэл хянан шалгасан талаарх дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл шийдвэрийг тайланд дурдахгүй болно.	сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	---	-------------------------	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
1	Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор нээлттэй мэдээллийн нэгдсэн “shilen.gov.mn” системд салбарын мэдээллийн ил тод байдлыг хариуцан ажиллах	Сайдын 2025 оны А/104 дүгээр тушаал	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, салбарын бодлого үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах хүрээнд байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод байдлыг яамны цахим хуудаст байршуулсан.

2	Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу магадлан шалгах ажиллагаа явуулах ажлын хэсэгт ажиллах	Сайдын 2025 оны А/220 дугаар тушаал	Музейн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу магадлан шалгах ажиллагаа явуулах ажлын хэсэгт ажиллаж хүсэлт ирүүлсэн 3 музейн баримт бичгийг нягтлан шалгаж тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт санал өгсөн.
3	“Аялал жуулчлалын үндэсний хөгжийн стратеги” төлөвлөгөө боловсруулах, “Go Mongolia” үндэсний брэндийг олон улсад сурталчлан таниулах нэгдсэн стратеги боловсруулах гэрээнүүдийн биелэлтийг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт ажиллах	ТНБД-ын 2025 оны А/37 дугаар тушаал	Аялал жуулчлалын тухай хууль, Монгол Улсыг олон улсад сурталчлах бодлогын зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Бостон консалтинг групп”-тэй байгуулсан “Аялал жуулчлалын үндэсний хөгжийн стратеги” төлөвлөгөө боловсруулах, “Эдэлман Сингапур Компани”-тай байгуулсан “Go Mongolia” үндэсний брэндийг олон улсад сурталчлан таниулах нэгдсэн стратеги боловсруулах гэрээнүүдийн биелэлтийг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт ажиллаж дүгнэлт гарсан.
4	“Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах”	Боловсролын сайдын 2025 оны А/191 дүгээр тушаал	Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх бодлогын агуулгыг Боловсролын судалгааны хүрээлэнгээс сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн төсөлд тусгуулах хүрээнд 1-2 дугаар ангийн сургалтын төлөвлөгөөний төсөл, сургалтын хөтөлбөрийн төсөлд санал, зөвлөмж хүргүүлэв.

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан богино болон дунд хугацааны	Сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн	2	1-ээс доошгүй сургалтад хамрагдах	Удирдлагын академийн Төрийн албан сургуулиас зохион байгуулсан "Төрийн байгууллагын стратегийн төлөвлөлт" сэдэвт сургалтад хамрагдаж №Z0329 дугаар үнэмлэх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	100%

	сургалтад хамрагдана	байна.			авсан. Тус сургалтын хөтөлбөрийн хүрээнд дараах сэдвээр нийт 16 цагийн хичээл судасан. Үүнд: -Төрийн байгууллагын стратегийн удирдлага -Мандат, алсын хараа, эрхэм зорилго тодорхойлох -Орчны шинжилгээ хийх -Стратеги тодорхойлох -Мандат алсын хараа, эрхэм зорилго тодорхойлох практик дадлага -Орчны шинжилгээ практик дадлага -Стратеги тодорхойлох практик дадлага дүгнэлт Хавсралт: 1 файл	сар, 11-р сар, 12-р сар	
--	-------------------------	--------	--	--	---	----------------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, судалгаа, тайлагналт хариуцсан Ахлах шинжээч, Лувсанзундуй Ариунтунгалаг

1. 

Огноо: 2025.6.10

СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН САЛБАРЫН НЭГДСЭН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА, ТАЙЛАГНАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ ЛУВСАНЗУНДУЙН АРИУНТУНГАЛАГИЙН 2025 ОНЫ
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Стратеги, бодлого төлөвлөлтийн газар**

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
1.2.Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиг хандлагыг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлно.					
1	Арга хэмжээ 1: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах	60	10	70	
2	Арга хэмжээ 2: Салбарын улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	60	10	70	
3	Арга хэмжээ 3: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлах	60	10	70	
4	Арга хэмжээ 4: “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын 2020-2025 оны хэрэгжилтийн тайлан боловсруулах дэд ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
5	Арга хэмжээ 5: Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсийн зөвлөлийн хуралдаанд хамтран ажиллах	60	10	70	
6	Арга хэмжээ 6: ААНОАТТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.9.3, 22.9.6-т заасны дагуу соёл,	60	10	70	

	спортын салбарын хөнгөлөлт эдлэх шаардлага боловсруулж батлуулах, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх				
3.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах					
7	Арга хэмжээ 1: Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Байгууллагын стратегийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулах	30	5	35	
3.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах					
8	Арга хэмжээ 1: ССАЖЗ-ын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд ажиллах	60	10	70	
Нэмэлт ажлын биелэлт					
9	Арга хэмжээ 1: Сайдын 2025 оны А/104 дүгээр тушаал: Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор нээлттэй мэдээллийн нэгдсэн "shilen.gov.mn" системд салбарын мэдээллийн ил тод байдлыг хариуцан ажиллах	60	10	70	
10	Арга хэмжээ 2: Сайдын 2025 оны А/220 дугаар тушаал: Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу магадлан шалгах ажиллагаа явуулах ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
11	Арга хэмжээ 3: ТНБД-ын 2025 оны А/37 дугаар тушаал: "Аялал жуулчлалын үндэсний хөгжийн стратеги" төлөвлөгөө боловсруулах, "Go Mongolia" үндэсний брэндийг олон улсад сурталчлан таниулах нэгдсэн стратеги боловсруулах гэрээнүүдийн биелэлтийг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
12	Арга хэмжээ 4: Боловсролын сайдын 2025 оны А/191 дүгээр тушаал: "Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах"	60	10	70	
Дундаж оноо:				67.	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Арга хэмжээ 1. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана.	100	15	
Дундаж оноо:			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	6.5	
2	Дүн шинжилгээ хийх	6.5	
3	Асуудал шийдвэрлэх	6.5	
4	Хариуцлагатай байдал	6.5	
5	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	-	-
7	Мэргэжлийн ур чадвар 2.	-	-
8	Мэргэжлийн ур чадвар 3.	-	-
Дундаж оноо:		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-8 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	8	
2	Багаар ажиллах	8	
3	Харилцаа	8	
Дундаж оноо:		8	

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	67
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо:		96.6 / 95.6

Үнэлгээ өгсөн:

Нэгдсэн төлөвлөлтийн
хэлтсийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


(гарын үсэг)

(Д.Мөнхцэцэг)
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

Цахим бодлого, статистик
мэдээллийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
(албан тушаал)


(гарын үсэг)

(Ч.Энхтуяа)
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Салбарын нэгдсэн бодлого,
төлөвлөлт, судалгаа, тайлагналт
хариуцсан Ахлах шинжээч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

(Л.Ариунтунгалаг)
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж, ахлагч


Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга
(албан тушаал)


(гарын үсэг)

(Д.Түмэндэмбэрэл)
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....
(албан тушаал)


(гарын үсэг)

(Ч.Огочнбат)
(албан хаагчийн нэр)
2025.06.16 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


(гарын үсэг)

(С.Оюунбилэг)
(албан хаагчийн нэр)
..... (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ, СООТОНГОО МӨНХ-ЭРДЭНЭ
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг судалгаа шинжилгээнд тулгуурлан боловсронгуй болгоно.							
1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах	Салбарын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийн тоо Баримт бичигт тусгасан арга хэмжээний тоо	ЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын арга хэмжээ тусгагдаж батлагдсан байна.	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтад үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга	6-р сар	100%

					хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.4 дахь хэсэгт тусгагдсан "Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг" гэсэн зорилгын хүрээнд 4 зорилт, 9 арга хэмжээг тусгасан.		
2	Салбарын улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулах	Төлөвлөгөөний төсөл -1 Хүргүүлсэн албан бичиг	УИХ-ын 2024 оны 35 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд салбарын арга хэмжээ тусгагдаж батлагдсан байна.	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтад үндэслэн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын салбарын Хүн амын бие бялдрын түвшин тогтоох цахим төвийн байгуулах арга хэмжээг тусгуулсан.	6-р сар	100%
3	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах	Стратеги төлөвлөгөө -1	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна.	Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн "Стратеги төлөвлөгөө батлах тухай" А/78 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-нд стратегийн зорилго 4-т "Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлэж, спортын амжилтыг олон улсын	3-р сар	100%

					хэмжээнд дээшлүүнэ" гэж , зорилгыг хэрэгжүүлэх 4 зорилтыг тусган батлагдсан.		
4	Бүсүүдэд зохион байгуулагдах Засгийн газрын өргөтгөсөн хуралдааны салбар хуралдаанд салбарын саналыг боловсруулах	Салбарын саналын тоо	-	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийг аймаг, дүүрэгт байгуулах санал боловсруулах	Бүсүүдэд зохион байгуулагдах Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанд хэлэлцүүлэх биеийн тамир, спортын салбарын саналд "Бүх аймаг, дүүрэгт хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төв байгуулах"-ыг санал боловсруулж, хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төв байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийн барилга барих төсвийг 38.9 тэрбум төгрөг байхаар тооцож, саналыг салбарын бүсчилсэн хөгжлийн асуудал хариуцсан шинжээчд хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	4-р сар	100%
5	Залуучуудын тоон судалгаа хийх	Ажлын даалгавар -1 Судалгааны тайлан -1	-	Хууль, стратеги боловсруулахад шаардагдах тоон судалгааны хийсэн байна.	"Залуучуудын хөгжлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдох статистик үзүүлэлтийн эмхэтгэл /2016-2023 он/-ийн мэдээллийг оноор болон салбараар авч	4-р сар	100%

					эмхэтгэсэн ч тайлан хэлбэрт оруулж бэлтгээгүй болно. Тус статистикийн үзүүлэлтийн эмхэтгэлд Статистикийн үндэсний хороо, бусад салбарын статистик мэдээ, олон улсын байгууллагаас гаргасан судалгааны дүнг багтсан бөгөөд Залуучуудын хөгжлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд эмхтгэж, 2016 оноос хойших бүхий л тоон мэдээг нэтгэсэн болно. Хавсралт: 1 файл		
3.1. Биеийн тамир, спортын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах							
6	Монгол Улсыг төлөөлөн олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны дүрэм боловсруулж, батлуулах	Дүрэм - 1	Үндэсний хороогоор батлагдсан дүрэмтэй	Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна.	Монгол Улсыг төлөөлөн олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны дүрэм боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлахаар дэмжүүлсэн. Монгол Улсыг төлөөлөн олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ	3-р сар	100%

					багийн бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны дүрэм одоогоор албажиж ирээгүй байна.		
7	Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх шалгуур үзүүлэлт боловсруулж, батлуулах	Шалгуур үзүүлэлт -1	МУС, ОНБТСҮХ-ны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-тай	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна.	Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дахь заалтыг үндэслэн "Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт"-ийг боловсруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн "Шалгуур үзүүлэлт, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" А/23 дугаар тушаалаар батлуулсан. Хавсралт: 2 файл	3-р сар	100%
8	Өсвөр үе, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт явуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах журам боловсруулж, батлуулах	Журам -1	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна.	Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг үндэслэн Өсвөр үе, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт явуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах журам боловсруулж, спортын	6-р сар	100%

					асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд одоогоор "МОНГОЛ УЛСЫН ТАМИРЧНЫ УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗАГВАР"-ыг Канад, Швейцар улсын туршлага дээр үндэслэн боловсруулж байна. Хавсралт: 2 файл		
9	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах	Шалгуур үзүүлэлт -1	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлтгэж байна. Хавсралт: 1 файл	6-р сар	50%
10	Спортын тэмцээн, наадмын норматив, шаардлага, нээлт, хаалтын дэг, соёл, удирдлага, зохион байгуулах журам боловсруулж, батлуулах	Журам -1	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлагдсан байна	Биеийн тамир, спортын тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалтыг үндэслэн Спортын тэмцээн, наадмын норматив, шаардлага, нээлт, хаалтын дэг, соёл, удирдлага, зохион байгуулах журмын төслийг боловсрууллаагүй байна	6-р сар	0%
11	Орон нутгийн	Журам -1	-	Соёл, спорт, аялал	Биеийн тамир, спортын	6-р сар	100%

	биеийн тамир, спортын байгууллага биеийн тамир, спортын хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тариф, орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах			жуулчлал, залуучуудын сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар шинэчлэн батлуулсан байна.	тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтыг үндэслэн "Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага биеийн тамир, спортын хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тариф, орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг төслийг боловсруулж, орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагаас үйлчилгээний тарифын санал авсан боловч 8 нэгжээс санал ирүүлсэн тул дахин санал ирүүлэхээр чиглэлийг эдгээр байгууллагад хүргүүлсэн. Улсын хэмжээнд мөрдөх биеийн тамир, спортын үйлчилгээний тарифын саналыг нэгтгэмэгц ТНБД-ийн зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэж байна. Хавсралт: 2 файл		
12	Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж,	Журам -1	Эрүүл мэндийн сайд, Сангий сайдын хамтарсан 2009 оны 53/45 дугаар тушаал	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар шинэчлэн батлагдсан байна.	Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дахь заалтыг үндэслэн "Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг	6-р сар	100%

	батлуулах				зохион байгуулах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулсан. Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.8, 10.1.9 дахь заалтыг үндэслэн олон улсын тэмцээн, наадам болон улсын хэмжээний тэмцээн, наадмын харилцааг зохицуулах 4 журам боловсруулах ёстой бөгөөд Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалтыг үндэслэн боловсруулах 2 журмын агуулгатай уялдуулахаар түр хугацаагаар зогсоосон. Хавсралт: 1 файл		
13	"Монгол Улсад 2025 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт"-батлуулах;	Жагсаалт - 1	"Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт" батлуулж байсан	Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна.	Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн "Монгол Улсад 2025 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн "Жагсаалт	6-р сар	100%

					батлах тухай" 243 дугаар тогтоолоор батлуусан. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
1.	Хангай, Говь, Төвийн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнд Биеийн тамир, спортын салбарын бодлогын талаар илтгэл тавьж оролцсон	ТНБД	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ


№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
	Бусад улсын урт хугацааны бодлогын баримт бичиг болон спортын сургалт-дасгалжуулалт, индекс тооцох аргачлалыг судална	3 баримт бичиг судална.	-	Биеийн тамир, спортын хуулийг дагаж гаргах эрх зүйн баримт бичиг боловсруулахад ашиглах судалгаа хийсэн байна	Healthy Physical Activity Environment Policy Index (PA-EPI) судлаж нэвтрүүлэх талаар судалж байна.	01.01-06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Биеийн тамир, спортын бодлого, төлөвлөлт, тайлагналт, судалгаа хариуцсан шинжээч, Соотонгоо Мөнх-Эрдэнэ

/...../

Огноо: 2025.06.10



СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ СООТОНГООГИЙН МӨНХ-
ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Стратеги, бодлого төлөвлөлтийн газар**

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Салбарын хууль, эрх зүйн орчныг судалгаа шинжилгээнд тулгуурлан боловсронгуй болгоно.					
1	Арга хэмжээ 1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах	60	10	70	
2	Арга хэмжээ 2. Салбарын улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулах	60	10	70	
3	Арга хэмжээ 3. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах	60	10	70	
4	Арга хэмжээ 4. Бүсүүдэд зохион байгуулагдах Засгийн газрын өргөтгөсөн хуралдааны салбар хуралдаанд салбарын саналыг боловсруулах	60	10	70	
5	Арга хэмжээ 5. Залуучуудын тоон судалгаа хийх	60	10	70	
Зорилт 2. Биеийн тамир, спортын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах					
1	Арга хэмжээ 1. Монгол Улсыг төлөөлөн олимп, паралимпын	60	10	70	

	наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны дүрэм боловсруулж, батлуулах				
2	Арга хэмжээ 2. Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх шалгуур үзүүлэлт боловсруулж, батлах	60	10	70	
3	Арга хэмжээ 3. Өсвөр үе, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт явуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах журам боловсруулж, батлах	60	10	70	
4	Арга хэмжээ 4. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлах	30	5	35	
5	Арга хэмжээ 5. Спортын тэмцээн, наадмын норматив, шаардлага, нээлт, хаалтын дэг, соёл, удирдлага, зохион байгуулах журам боловсруулж, батлах	0	0	0	
6	Арга хэмжээ 6. Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага биеийн тамир, спортын хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тариф, орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	60	10	70	
7	Арга хэмжээ 7. Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж, батлах	60	10	70	
8	Арга хэмжээ 8.	60	10	70	

	"Монгол Улсад 2025 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт"-батлуулах;				
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1	Арга хэмжээ 1. Хангай, Говь, Төвийн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнд салбарын бодлогын талаар илтгэл тавьж оролцсон.	60	10	70	
Дундаж оноо:				62.5	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Арга хэмжээ 1. Бусад улсын урт хугацааны бодлогын баримт бичиг болон спортын сургалт-дасгалжуулалт, индекс тооцох аргачлалыг судална	100	15	
Дундаж оноо:			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	7	
2	Дүн шинжилгээ хийх	7	
3	Асуудал шийдвэрлэх	7	
4	Хариуцлагатай байдал	7	
5	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.		
7	Мэргэжлийн ур чадвар 2.		
8	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо:		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-8 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	8	
2	Багаар ажиллах	8	
3	Харилцаа	8	
Дундаж оноо:		8	

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	62.5
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо:		92.5 / 87.5

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Нэгдсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга
(албан тушаал)

(гарын үсэг)

/Д.Мөнхцэцэг/
(албан хаагчийн нэр)

(огноо)

Цахим бодлого, статистикийн хэлтсийн
Даргын албан үүргийн түр
орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

(гарын үсэг)

/Ч.Энхтуяа/
(албан хаагчийн нэр)

(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Шинжээч
(албан тушаал)

(гарын үсэг)

/С.Мөнх-Эрдэнэ/
(албан хаагчийн нэр)

2025.06.17 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж,
ахлагч:

(албан тушаал)

(гарын үсэг)

/...../
(албан хаагчийн нэр)

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

(албан тушаал)

(гарын үсэг)

/Ч.Осгонбат/
(албан хаагчийн нэр)

2025.06.16 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн
Даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
(албан тушаал)

(гарын үсэг)

/С.Оюунбилэг/
(албан хаагчийн нэр)

(огноо)



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ,
БУЯНХИШИГ ОДБАЯР2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт			
	1	2	3	4	5		6	7
1.1. 1.1 Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиг хандлагыг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлно.								
1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Стратеги төлөвлөгөө батлагдсан байна.	Хамтран ажиллах гэрээг 2024 онд байгуулсан.	Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөний ажлыг хүлээн авсан байна.	Аялал жуулчлалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 2024-2028 онд ЗГҮАХХАХ-ний 3.3.5-Дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх гэж заасны дагуу Аялал жуулчлалын үндэсний хөглийн стратеги боловсруулахаар "Бостон консалтинг" групп-тэй 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний биелэлтийг Соёл,спорт, аялал жуулчлал, залуучуудын		5-р сар, 6-р сар	100% 90%

					сайдын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/37 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулагдан хүлээн авч Сайдын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/190 тушаалаар Стратеги төлөвлөгөөг баталсан. Хавсралт: 4 файл		
2	Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлал боловсруулах	Үзэл баримтлал -1	Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлал боловсруулагдсан.	Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлалын төслийг боловсруулсан байна.	Аялал жуулчлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.7.аялал жуулчлалын бүсийн нөөц, даацыг тогтоох, аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх, Монгол Улсын засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дугаар тогтоолоор "Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс" болгон зарлсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% ! 30%

					ний өдрийн А/172 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хавсралт: 3 файл		
3.1. 1.2 Аялал жуулчлалын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах							
3	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг боловсруулж, батлуулах	Журам -1	Журмын төслийг боловсруулсан.	Журмыг хэлэлцүүлсэн байна.	Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д Энэ хуулийн 6.2.3-т заасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг төслийг боловсруулан аялал жуулчлалын мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100% 30%

					Хавсралт: 1 файл		
4	Аялал жуулчлалын бүс тогтоох шалгуур үзүүлэлтийн дагуу улсын аялал жуулчлалын бүс тогтоох	Шалгуур үзүүлэлт -1 Засгийн газрын тогтоол -1	Аялал жуулчлалын 7 бүсчлэл, 66 орон зайг тодорхойлсон	Шалгуур үзүүлэлт боловсруулсан байна.	Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн Засгийн газраас тогтоож, хилийн заагийг батална гэж заасны дагуу Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан зорилго, зорилтын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Аялал жуулчлалын хөгжүүлэх өв соёл, аялал жуулчлалын нөөц, байгалийн аялал жуулчлалын нөөц, тусгай сонирхлын аялал жуулчлалын нөөц тэдгээрийг газар зүйн байршилтай уялдуулан орон зайн дүн шинжилгээ хийж 66 аялал жуулчлалын микро бүсүүдийг ward-ын аргыг ашиглан тээвэр дэд бүтэц, логисток, эдийн засгийн коридор бүс нутгийн эдийн засгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	50%

					интеграци, Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот суурийн газар зэргийг харгалзан 6 аялал жуулчлалын бүсийг тодорхойлсон. Нийт 66 улсын аялал жуулчлалын бүсийг тодорхойлон эрэмбэлэн Засгийн газрын хуралдаанаар оруулхаар бэлтгэж байна. Хавсралт: 1 файл		
